



ӨВС ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

ТШ-ын код: ХӨАЦУСЗДТГ/20240202088

ТШ-ын нэр: Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

I. Бэлчээрийн өвсний техникийн тодорхойлолт

1. Барааны тодорхойлолт

1.1. 2024 оны намрын ургацаас бэлтгэсэн ногоон, цайвар ногоон өнгөтэй, өвсний өвөрмөц анхилам үнэртэй, гадны ямар нэг үнэргүй байх

1.2. Өвс цайж хөхрөөгүй, харлаж борлоогүй, хөгцрөөгүй байх

1.3. Харлаж, хөгцөрсөн, ялзарч муудсан өвсийг сумын нөөцдөд нийлүүлэхийг хориглоно.

№	Үзүүлэлтүүд	Хэмжээ
1	Сөөг, сөөгөнцөр ургамал /хувиас дээшгүй/	10
2	Хорт ба хөнөөлт ургамал /хувиас дээшгүй/	0,5
3	Хагд өвсний хэмжээ /хувиас дээшгүй/	15
4	Чийг /хувиас дээшгүй/	17
5	Нийт эслэг /хувиас дээшгүй/	28
6	Элс, шорооны хольц /хувиас дээшгүй/	0,5
7	Нийт протейн /хувиас доошгүй/	10
8	Каротины хэмжээ 1 кг-д /хувиас доошгүй/	20
9	Нэг боодол өвсний нягтрал /кг/ метр кубаас доошгүй	120
10	Нэг боодол өвсний хэмжээ /см/-зэр	50*30*80
11	Нэг боодол өвсний жин /кг/	20

1.4. Байгалийн болон таримал хадлан /өвс/-ын ургамлын бүтээгдэхүүн нь стандарт /MNS 0592:2008/ үзүүлэлт, хүснэгтэнд заасан шаардлагыг хангасан байна.


1.5. Мал, амьтны гоц халдварт өвчингүй бус нутгаас бэлтгэсэн байх

2. Баглаа боодол: MNS 0592:2008 улсын стандарт хангасан байна. Өвсний боодол задраагүй байх /шаардлага хангаагүй өвсийг хүлээн авахгүй/ машинаар тээвэрлэлт хийх тохиолдолд бороо, шорооноос хамгаалсан хучлагатай байх, зарлагын баримттай байна.
3. Таримал ногоон тэжээлийг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах
4. Таримал ногоон тэжээлийг нийлүүлэхдээ гарал үүслийн тодорхойлолт, стандартад тэнцсэн шинжилгээний дүнг дагуулан хүргүүлнэ.
5. Өвсийг цас, бороо, чийг ба асгаж үрэгдүүлэхээс хамгаалж, MNS 5647:2006 -ийн дагуу тээвэрлэнэ.
6. **Бараа хүргэх газар:** Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын төвд байрлах Сумын аюулгүй нөөцийн агуулахын хашаанд байрлах агуулах
7. Цагаан-Уул сумын нөөцөд нийлүүлэх 20 000 000 төгрөгний 1482 боодол пресс буюу 29,64 тонн өвсийг зориулалтын мяндсан утсаар боосон байх бөгөөд сумын аюулгүй нөөцийн агуулахад ачиж ирсэн өвсийг буулгаж хураах ажлыг тухайн гүйцэтгэгч компани мөн хариуцна.
8. Хүнс, хөдөө аж ахуйн газрын улсын байцаагчийн дүгнэлттэй байх /Лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байна/
9. Бараа нийлүүлэлтийн хуваарийг тендерийн баримт бичигт заасан дагуу ирүүлэх
10. Тендерт шалгарсан хуулийн этгээд нь барааг тээвэрлэх, ачих /сумын аюулгүй нөөцийн агуулахад буулгах/ болон татварын шимтгэлийг тендерийн үнэд багтаан тооцсон байх
11. Тендерт оролцогч хуулийн этгээд нь захиалагчид нийлүүлэх барааны дээж /1-2 боодол өвс/-ийг тендер нээхээс өмнө ирүүлсэн байх.

БОЛОВСРУУЛСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:  У.АВАРЗЭД

ГИШҮҮН: З. Азза 3.АЗЗАЯА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:  М.ОЮУНЧИМЭГ